



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3 нэрийн, нийт 99,472,544.52 (ерэн есөн сая дөрвөн зуун далан хоёр мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь Мал эмнэлгийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ  
132001026  
4-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 1 дугаар сарын 08-ны/ний өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАТЫН  
СЭЛБЭГЭЭР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д                                    | Хөрөнгийн нэр, төрөл         | Улсын дугаар, сери | Арлын дугаар      | Үйлдвэрлэс эн, Ашиглалта д орсон огноо | Тоо хэмжээ (ширхэг) | Явсан км | Нэг бүрийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                      | Сэлбэгээр худалдах доод үнэ (төгрөг) |
|--|------------------------------|--------------------|-------------------|--|---------------------|----------|--|--------------------------------------|
| ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР     |                              |                    |                   |  |                     |          |  |                                      |
| 1                                      | УАЗ-390945 фермер            | 30-313АН           | 330360С0494613    | 2012/20125                             | 1                   |          | 40,948,772.52  | 900,000.00                           |
| ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР |                              |                    |                   |  |                     |          |  |                                      |
| 2                                      | Уаз 22069 Фургон /автомашин/ | 67-66ӨВА           | 70406118          | 1.00                                   | 1                   |          | 17,575,000.00  | 1,000,000.00                         |
| ХЭНТИЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР     |                              |                    |                   |  |                     |          |  |                                      |
| 3                                      | УАЗ-390945 фермер            | 26-06ХЭҮ           | ХТТ390945С0471947 | 2012/2012                              | 1                   | 523810   | 40,948,772.00  | 900,000.00                           |
|  |                              |                    |                   |  |                     |          | 99,472,544.52  | 2,800,000.00                         |
|  |                              |                    |                   |  | 3                   |          | (ерэн есөн сая дөрвөн зуун далан хоёр мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг тавин хоёр мөнгө) | (хоёр сая найман зуун мянга)         |
|  | НИЙТ ДҮН                     |                    |                   |  |                     |          |  |                                      |